

Төмөрбаатарын Түвшинжаргал^{1,✉}, Ганболдын Анхсанаа²

¹Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр
²Соёлын өвийн үндэсний төв, Монгол улс, Улаанбаатар-17120,
Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 2, Соёлын өвийн үндэсний төв

Хадны зураг дахь үхэр тэрэгний дүрслэл

Товчлол. Монгол улсын бүс нутгийн хүрээнд үхэр тэрэгний үүсэл, хөгжил болон эртний баримт хэрэглэгдэхүүний талаар тухайлан өгүүлсэн нь үгүй бөгөөд магадгүй хадны зураг дахь үхэр тэрэгний дүрслэл нь морин тэрэгтэй харьцуулахад маш цөөн тоотой илэрч олдсон байдаг тул судлаачдын анхаарлыг тэр бүр татдаггүй байж болох талтай. Энэ удаад бид Монгол улсын нутгаас илэрч оллоод буй хадны зураг дахь 18 үхэр тэрэгний зургийг нэгтгэн авч үзсэн бөгөөд үүнд үхэр тэрэгний хөгжлийн эхэн үе буюу түрүү болон хөгжингүй хүрлийн үеийн 3 (?), хожуу хүрлийн 4, түрүү төмөр болон эртний улсуудын үед холбогдох 8 дурсгалт газрын 11 хадны зургийн үхэр тэрэгний талаар өгүүлэв. Судалгааны үр дүнгээс харахад дэлхий нийтэд тэрэг анх дэлгэрсэн он цагаас төдий л хожуугүй буюу НТӨ III мянган жилийн эхэн үеэс Алтайн бүс нутагт тархсан Афанасьев болон Хэмцэгийн соёлт ард түмэн үхэр тэргийг энэ бүс нутагт анхлан ашиглах болсон байх дүр зураг харагдаж байна. Харин хожуу хүрлийн үе буюу НТӨ II мянганы сүүл хагас НТӨ I мянган жилийн эхэн үеэс хөнгөн тэргэнд адуу хөллөх явдал түгээмэл дэлгэрсэн учир үхрийг тэргэнд хөллөх эсвэл үхэр тэргийг хаданд сийлэх нь ховор байжээ. Хүннү болон эртний улсуудын үеэс босоо мухлагтай эсвэл сүйх тэргэнд адуунаас гадна үхэр хөллөх болсон ба нүүдэлчдийн хөдөлгөөнт амьдралын хэв маягт зохицсон гэр хэлбэрийн жижиг мухлагтай тэрэгний хэлбэр ч энэ үеэс бий болж улмаар Монголын эзэнт гүрний үед олон үхэр хөллөдөг нүсэр том гэр тэргийг ашиглах болжээ. Эцэст нь тэмдэглэхэд Евразийн бүс нутагт аль түрүү хүрлийн үеэс эхлэн түүхэн ихэнх цаг үед тэрэг нь оршуулгын зан үйлийн нэгэн чухал бүрдэлдэхүүнд багтаж байсан бөгөөд үүний илрэл нь хадны зургийн зарим тэрэгний дүрслэлд ч тусгагдсан байх магадлалтай байна.

Түлхүүр үгс: *Үхэр тэрэг, гэр тэрэг, хадны зураг, түрүү хүрлийн үе, хожуу хүрлийн үе, хүннүгийн үе*

Tuvshinjargal Tumurbaatar^{1,✉}, Ankhsanaa Ganbold²

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia
²National center of Heritage culture,
Buyant-Ukhaa 2, Khan-Uul district,
Ulaanbaatar-17120, Mongolia

Representation of early cattle carts in Mongolian petroglyphs

Summary. Wheeled transport using cattle and other large bovinds is a core element of pastoral tradition in some areas of eastern Eurasia, and recent archaeological data suggests that cattle transport likely served as the earliest form of animal transit in the eastern reaches of the Eurasian steppe. While many rock art images of early cattle show activities such as riding or pack-carrying and horse carts/chariots are common in late Bronze Age imagery, however, almost no direct evidence characterizes the use of wheeled cattle-drawn carts in the region's archaeological record. In this paper, we synthesize archaeological evidence for cattle-drawn vehicles in ancient Mongolia, including both newly-discovered and previously published petroglyphs. Our results suggest that during the Early Bronze Age (3rd millennium BCE), four wheeled carts likely were pulled by cattle. These images show chronological patterning in their style of depiction, with Early to Late Bronze Age vehicles depicted in dorsal, top-down view, and later images linked to the Early Iron Age and early pastoral empires shown in lateral profile. By the second half of the 2nd millennium BC, rock art imagery shows horses widely used to pull chariots and occupied a special place in social life and with a human consciousness due to their speed which might have caused the scarcity of cattle cart depiction in petroglyphs. In Eurasia since the Early Bronze Age, carts were an important part of burial rituals for most historic periods, and it is likely that some carts depicted in rock paintings are also linked with ritual activity.

Keywords: Cattle cart, rock art, Early Bronze Age, Late Bronze Age, Xiongnu period, and Mongolia

Удиртгал

Хүн төрөлхтөн бод малаас үхрийг хамгийн эрт гаршуулсан учраас ачилга тээврийн зүтгэх хүчээр адуу, тэмээнээс эрт үед үхрийг ашиглах болжээ. Еврази болон Ойрх дорнодын бүс нутгаас илэрсэн үхэр тэрэгний эртний баримтууд ойролцоо цаг үед буюу НТӨ IV-III мянган жилд холбогддог учир тэргийг нэг бүс нутагт анхлан зохион бүтээж үүсээд бусад бүс нутаг руу тархсан гэх баттай баримт одоогоор үгүй байна. Энэ нь тэрэг анх өөр өөр бүс нутгуудад нэг цаг үед бие биеээсээ үл хамааран үүссэн байх магадлалтайг харуулж буй юм. Тухайлбал, НТӨ IV мянганы дунд үед холбогдох Төв Европын Юүлүүр хэлбэрт ваарын соёл (Funnel Beaker culture)-ын вааран дээр дүрсэлсэн тэрэгний зураг (Kowaloski et al. 2019), өмнөд Месопотамас олдсон НТӨ IV мянганы төгсгөлд холбогдох шавраар хийсэн 4 дугуйт тэрэг болон үхэрт хөллөсөн чарга (Anthony 2007; Novozhenov 2012; Sherratt 1981), мөн НТӨ IV мянганы төгсгөлд хамаарах Кавказын умард хэсэгт дэх Майкопын соёлын Маринын булшнаас төмөрлөг дөрийн хамт олдсон үхрийн эвэртэй хоёр толгой (Reinhold et al. 2017), наашлаад Евразийн зүүн бүсэд Понти-Каспын орчмын Ямны болон Новотитаровкийн (НТӨ 3300-2600) соёлын булшнаас 2 үхэрт хөллөдөг 4 дугуйт тэрэг олддог (Anthony 2007; Гей 2000; Kuzmina 2008; Morgunova and Turetsky 2003; Reinhold et al. 2017) төдийгүй Понти орчмын Ямны соёлыг залгамжлагч Катакомбийн соёл (НТӨ 2500-2000)-ын оршуулгаас мөн хигээсгүй цул дугуй бүхий тэрэгнүүд олонтоо илэрсэн (Shishlina et al. 2014) бөгөөд эдгээр нь үхэр тээврийн эртний баримтууд болно.

Харин Өмнөд Сибирийн Минусын хотгороор төвлөрөн орших түрүү хүрлийн үеийн Окуневын соёл (НТӨ 2500-1800)-ын хөшөө болон хавтан чулуунд 4 болон 2 дугуйт үхэр тэргийг дүрсэлсэн байдаг (Есин 2018; Новоженов 2014) нь Евразийн зүүн хэсэг дэх үхэр тэрэгний эртний баримтад зүй ёсоор тооцогддог.

Харин монгол нутаг дахь үхэр тэрэгний үүсэл, хөгжлийн асуудлыг нарийвчлан судлахад хадны зураг дахь дүрслэл чухал хэрэглэгдэхүүн болох ч энэ талаар тухайлсан судалгаа ерүүгүй юм. Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Дэл уулнаас илэрсэн хүннүгийн үед холбогдох мухлагт үхэр тэрэг болон Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Их бэрх уулын холбоо үхэр тэрэгнүүд нь харьцангуй олон хэвлэгдэж, судлаачдын дунд танигдсан байх бол бусад ихэнх тэрэг нь анх илрүүлсэн тухайн судалгааны тайлан, бүтээлд дурдагдах төдий мэдээлэгджээ. Тиймээс бид шинээр олдсон үхэр тэрэгний дүрслэлд тулгуурлан монгол нутгаас илэрсэн нийт үхэр тэрэгний дүрслэлийг нэгтгэн хэлэлцүүлж, тэдгээрийн загвар дүрслэл болон холбогдох он цагийн талаар өгүүлэхийн зэрэгцээ үхэр тэргийг хэдий үеэс өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэрийн хүрээнд анх ашиглах болсон хийгээд тэдгээрийн түүхэн хөгжил, уламжлалын талаар энэ удаад өгүүлэв. Ингэхдээ монголын археологийн судалгааны тайлан, өгүүлэл, ном бүтээлээс үхэр тэрэгтэй холбогдох зургуудыг түүвэрлэж, заримыг анх илрүүлсэн судлаачдын зөвшөөрөлтэйгөөр гар зурагт буулгасан төдийгүй, зарим дурсгалт газруудад бид өөрсдийн биеэр очиж зургийг хуулбарлах зэргээр судалгааны эх хэрэглэгдэхүүнээ бүрдүүлэв.

Түрүү болон хөгжингүй хүрлийн үе

Дэлхий дахинд үхэр тэрэг анхлан тархсан цаг хугацаанаас тийм ч хожуугүй Монгол болон Дотоод Азийн бүс нутагт үхэр тэрэг хэрэглэж эхэлсэн болохыг нотлох цөөн боловч баримтууд археологийн малтлага судалгаагаар илэрч олдсон байна. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт малтсан Хуурай говийн Афанасьевын соёлын булшнаас тэрэгний байж болох мод олдсон бөгөөд дөрвөлжин хүрээ модон дотор зөрүүлж тавьсан (“Х” хэлбэрийн) модыг Ямны соёлын ижил хэлбэрийн тэрэгний тэвштэй адилтгаж үзсэн байдаг (Kovalev and Erdenebaatar 2009; Ковалев, Эрдэнэбаатар 2014). Мөн тус булшнаас үхрийн ясны хэсгүүд илэрч олдсоныг мөн тодорхойлон судалсан байна (Саблин 2014). Энэхүү баримт нь бүрэн дүүрэн баталгаатай бус ч Монгол нутаг дахь хамгийн эртний тэрэгний хэрэглэгдэхүүн байх магадлалтай. Харин харьцангуй баттай гэж үзэж болох тэрэгний дүрслэл Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Хар чулуутын Хэмцэгийн соёл (НТӨ 2500-1800)-ын чулуун цогцолбороос илэрч олдсон билээ (Зураг 2а). Тус тэргийг дөрвөн дугуйтай, дэлгэмэл байдлаар дүрсэлсэн ба ямар нэг мал хөллөөгүй ажээ (Ковалев, Мунхбаяр 2015: 199). Уг тэргэнд үхэр хөллөдөг байх бүрэн боломжтой. Учир нь тус байгууламжийн хавтан чулуунд мөн үхэр хөтөлсөн зургууд дүрслэгдсэн байдаг (Ковалев, Мунхбаяр 2015: 194-195) төдийгүй Хэмцэгийн соёлын хэд хэдэн хүн чулуунд үхэр дүрсэлсэн байхын зэрэгцээ дээр нь дүрсэлсэн үхрийг нарийн зураасаар хүн чулууны гарт нь хөтлүүлсэн байдлаар холбосон тохиолдол ч байдаг (Ковалев 2012: 14, 38, 42, 50). Энэ нь тухайн соёлын аж ахуйд үхэр чухал үүрэг гүйцэтгэж байсныг давхар харуулах юм. Түүнчлэн Хар чулуутын тэрэгний дүрслэлтэй төстэй цул дөрвөн дугуйт тэрэгнүүд ихэвчлэн үхэрт хөллөгдсөн байдаг ба ийм хэлбэрийн тэрэг газар зүйн ойролцоо бүс нутаг болох Казахстаны зүүн өмнөд хэсэг дэх Сауыскандык (Мургабаев 2013; Самашев и др. 2014) мөн баруун хойд хэсэг дэх Кульжабасы (Kulzhabasy) (Байпаков, Марьяшев 2004; Rogozhinskiy 2011) зэрэг газраас илэрч олджээ (Зураг 2b).

Сауыскандыкийн хадны зургуудыг НТӨ III мянганы төгсгөл II мянганы эхэн үед холбогдуулан үзжээ (Мургабаев 2013: 64). Харин Хар чулуутын байгууламжийн малтлагаар илэрсэн модны нүүрсний дээжинд C14-ийн шинжилгээ хийхэд НТӨ 3040-2890 (4350+-40), 2900-2200 (3970+-95) гэсэн үнэмлэхгүй он цагууд гарсан байна (Ковалев, Мунхбаяр 2022: 85). Хэдийгээр Казакстаны хадны зураг дахь Хэмцэгийн төст хадны зургууд нь он цагийн хувьд арай хожуу үеийнх мэт сэтгэгдэл төрүүлж байгаа боловч түрүү

хүрлийн үеийнх байх боломжтой юм (Төрбат 2019 :14).

Археологич Я.Цэрэндагва Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг дахь Далан Түргэний хос толгойн хадны зургийн цул дугуйт хоёр тэрэгний дүрслэлийг хүрлийн эхэн үед буюу III мянганы сүүл үед холбогдох боломжтойг дурдсан байдаг (Цэрэндагва, Цэвээндорж 2016: 94, 100). Тус хоёр тэрэгний нэг нь сонирхол татахуйц билээ. Тухайлбал, Хоёр том дугуйт тэргийг үхэр, адуу, хүн зэргийн хамт дүрсэлсэн ба дүрслэхдээ хүн, малын ерөнхий гадаад тэгийг хөвөөлөн цохиж дүрсэлсэн байна (Зураг 3а). Тэрэг нь дөрвөлжин тавцан, богино арал, хөндлөн урт буулгатай ба тэрэгний дугуйг цагариг хэлбэртэй цохиж дараа нь дотор талыг нарийн зураасаар ташуу байдлаар хээлсэн нь хигээсгүй, битүү цул модон дугуй болохыг илтгэх ба тэрэгний дугуйн хажууд нэгэн үхэр дүрсэлсэн ажээ (Цэрэндагва, Цэвээндорж 2016: 94, 167). Тус үхрийн эвэр нь тэрэгний дугуйтай холбогдсон тул тодорхой биш, харин нөгөө үхэр нь ялимгүй босоо боловч зарим судлаачдын “S” хэлбэрийн хэмээн нэрлэдэг урагш түрж, үзүүр нь дээш эргэсэн эвэртэй. Энэ нь хэмцэгийн хадны зураг (Ковалев, Мунхбаяр 2015; Төрбат 2019) болон хүн чулуунд (Ковалев 2012) дүрслэгдсэн үхрийн эвэртэй төстэй гэж хэлж болно.

Түүнчлэн тэрэгний хөгжлийн эхэн үед хамааруулж болох тойм дүрслэлтэй үхэр тэрэгний нэгэн зураг Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулнын Баруун билүүний булгийн хадны зурагт тэмдэглэсэн байна (Санжмятав 1995: 42, таб 137-4). Тус зурагт нэгэн үхрийн ар талд дундаа цэг бүхий цагаригаар дугуй, тэдгээрийн дунд магадгүй тэрэгний арлыг илтгэх дөрвөлжин дүрс сийлжээ (Зураг 3b). Тус тэрэгний үхрийн урд талд бас нэгэн өөр үхэр байх бөгөөд тус хоёр үхэр нь урагш түрж, үзүүр нь ялимгүй дээш гэдгэр эвэртэй бөгөөд үхрийн ерөнхий биеийн тэгийг хөвөөлдөж цохиж, тодор талыг хэсгүүдэд хуваан алагласан байдал нь ялтгүй түрүү хүрлийн үеийн үхрийн загваруудыг санагдуулмаар юм. Үхрийг ийнхүү эрээлсэн байдал Алтай, Хангайн уулсын хадны зурагт цөөнгүй тохиолддог. Харин тэргийг хажуу талаас дүрслэх явдал өмнөд сибирийн түрүү хүрлийн үеийн Окуневийн соёлын хөшөө чулуунд тохиолддог. Дугуйг цагариг хэлбэрээр дүрсэлж, дунд нь цэг тавьсан ч хигээстэй дугуйг илтгэхгүй ба энэ нь зарим тохиолдолд цул дугуйны хялбарчилсан дүрслэл байж болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг билээ (Цэрэндагва, Цэвээндорж 2016: 94; Сэр-Оджав 1987). Тиймээс тус тэрэг нь түрүү болон хөгжингүй хүрлийн үед холбогдох боломжтой хэмээн үзэж байна.

Богинын амны Баян хайрханы хадны зураг ба хожуу хүрлийн үеийн үхэр тэрэг

Тус хадны зураг¹ нь Борнуур сумын төвөөс зүүн хойд зүгт 6 км зайд Богинын амны Баян хайрхан уулын энгэрт, далайн түвшнээс дээш 1140 м орчим өндөрт байрлана. Уулын урд зүгт хандсан нэгэн толигор эгц хаданд үхэр тэрэг болон хэдэн бугыг нэг дор дүрслэсэн байх бөгөөд ойр орчим өөр дүрслэлгүй.

Зургийн доод хэсэгт хэсэгт 4 дугуйт үхэр тэрэг дүрслэсэн ба тэргэн дээр нэг хүн сууж, мөн өөр нэг хүн тэргийг хөтөлсөн байх аж. Тэрэгний 4 дугуй цагариг хэлбэртэй бөгөөд хойд 2 дугуйг урд хоёр дугуйнаас жижиг дүрслэсэн онцлогтой. Урд хоёр дугуйн завсар хэсэгт байх тэрэгний тавцанг зууван дугуй хэлбэртэй дүрслэж, тавцангаас шулуун зураас татаж хойд 2 жижиг дугуйны гол тэнхлэгтэй холбосон байна. Тус тэрэг нь хоёр аралтай (гуятай). Тэрэгний арланд хомбон эвэртэй, өндөр сэрвээтэй үхрийг хөллөсөн ба үхрийн биеийн ерөнхий тэгийг хөвөөлөн цохиж, дотор орон зайг хортонтуулан цохисон. Үхрийн сүүл нь арагш хийссэн байдалтай бөгөөд үхрийг хамраас нь салаа уяа (эсвэл дөрийг томоор дүрслэсэн)-гаар нэг хүн хөтөлсөн байна. Тэргэн дээр сууж буй хүний толгойн үсийг арзайлган гүн цохиж гаргасан бөгөөд мөн арай гүехэн цохилтоор богино эвэр хэлбэрийн чихтэй малгай өмссөн мэт харагдана. Малгайн хэлбэр нь баттай бус тул гар зурагт арай бүдэг өнгөөр ялган харуулав (Зураг 4, 5с).

Зургийн дээд хэсэгт 5 бугыг загварчилсан байдлаар зүүн гар тийш хандуулан дүрслэсэн ба эхний (баруун гар талаас) бугын доод хэсэгт мөн дутуу цохиж үлдээсэн нэгэн дүрслэл буй нь өөр нэгэн буга сийлэх гэж байгаад орхисон бололтой.

Баруун гар талаас **нэгдүгээр** буюу тэргүүнд байгаа бугын их биеийг хөвөөлөн цохиж, хошуу болон эвэрний харааг “буган хөшөө”-ний адил загварчилсан дүрслэсэн буюу урт нарийн хошуутай мөн эвэрний хос харааг дух болон хошуу дээгүүр урагш түрж, үзүүрийг дээш эргэсэн байдлаар дүрслэсэн. Харин эврийг налуу байдлаар дээш тэмүүлсэн уртаар дүрслэсэн ч цохилтыг бүрэн гаргаагүй байна. Бугын урд хөл тодорхой бол богино боловч хойд хөл мэдэгдэж байна. Тус бугын нэг онцлог нь зооноос урд хөлийн хаа хүртэл татсан шулуун зураас дүрслэсэн байдал ажиглагдаж байна. **Хоёрдугаар**

буга нь нэгдүгээр бугын зоо нурууг даран байрласан бөгөөд их биеийг хөвөөлөн цохиж дотор талбайг цоохорлосон эсвэл бүх талбайгаар хонхойлон цохих гэж байгаад дутуу үлдээсэн бололтой. Бугын ерөнхий дүрслэл нэгдүгээр бугатай төстэй загварчилсан дүртэй бөгөөд чих болон хөл тодорхой дүрслэгдсэн байна. Тус бугын харааг нэг салаа мөн эврийн нэг бүдүүн салаа тодорхой дүрслэгдсэн байна. **Гуравдугаар буга** нь хоёрдугаар ард байрлах бөгөөд бугын биеийнх нь ерөнхий тэгийг тод хүрээлэн хөвөөлдөж сийлбэрлэсэн. Тус бугын хүзүүг доош тонгойж, толгойг эргэж харж буй байдлаар дүрслэсэн нь онцлог бөгөөд эвэргүй дүрслэсэн учраас согоо хэмээн үзэж болно. **Дөрөвдүгээр буга** нь согооны (гуравдугаар буга) ар талд дүрслэгдсэн бөгөөд их биеийг хөвөөлж, доторх орон зайг хоёрдугаар бугын адил цоохорлосон. Бугын чих болон эвэр хэсэг хадны хаганд дарагдаж харагдахгүй болсон. Тус бугыг мөн хоёр хөлтэй дүрслэж, мөн сэлтийг урт дүрслэсэн онцлогтой. Гурав болон дөрөвдүгээр бугын хүйсийг тодорхой харуулж зурсан нь онцлог бөгөөд согоо хөөж буй дайрын дүрслэлээс үзвэл энэ нь намар цаг (9-10 дугаар сар) буюу бугын ороо хөөцөөний улирлыг илэрхийлсэн гэлтэй. **Тавдугаар буга** буюу хамгийн ар талын бугыг хортонтуулан цоохорлох төдий дүрслэсэн ба бусад бугаас арай сондгой байрласан. Дүрслэлийн хувьд өмнөх 4 бугаас бага зэрэг ялгаатай сагсар бут хэлбэрийн эвэртэй, илүү том нүдтэй ба урд хөлийг гаргалгүй үлдээжээ. Нийт буга болон тэрэгний үхэр зэргийг хажуу талаас харсан хойд, урд гэсэн тус бүр 2 хөлтэй дүрслэсэн байна.

Баян хайрханы хадны зурагт дүрслэгдсэн 5 бугын ерөнхий загварчилсан шинж байдлаас харахад тус зургийг НТӨ XII-VII зуунд холбогдох буган хөшөөний он цагийн хүрээнд авч үзэх бололцоо олгож байгаа төдийгүй буган хөшөөнд цөөнгүй тохиолдох зооноос гуя хүртэл татсан байх шулуун зураас мөн нэгдүгээр буганд дүрслэгдсэн байгаа нь сонирхолтой юм.

Үхэр тэргийг дэлгэмэл байдлаар дээд талаас нь харуулан зурсан бол үхэр болон хөтөлж яваа хүнийг хажуу талаас харуулсан буюу өөр өөр өнцгөөс харсан байдлаар дүрслэсэн. Энэ мэт нэг тэрэгний зургийг хэд хэдэн байрлалаас харснаар дүрслэж тэрэг болон хүнийг бүхэлд нь үзүүлдэг өвөрмөц арга нь хүрлийн үеийн морин тэрэгний дүрслэлд өргөн дэлгэрсэн байдаг (Цэрэндагва, Цэвээндорж 2016: 95). Харин хожуу хүрлийн үед холбогдох хоёр дугуйг дээрээс буюу дэлгэмэл байдлаар, хөллөсөн үхрийг хажуугаас харуулан дүрслэсэн үхэр тэрэг одоогоор хоёр л бүртгэгдсэн байгаа бөгөөд эдгээр нь Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Өвөр хадны Ихэр (Зураг 5а), (Баасандорж 2018: 76-77) болон Чандмань сумын

¹ 2022 онд Чингис Соосэ Олон Улсын Харилцааны сургуулийн 2 дугаар дамжааны оюутан Г.Шижирдалай нь төрөлх нутаг болох Төв аймгийн Борнуур сумаас хадны зураг нээж илрүүлсэн тухайгаа цахим орчинд нийтэлсэн бөгөөд мэдээллийн мөрөөр тус оны 3 дугаар сард судлаачид дурсгалт газарт очиж, зургийг нягтлан шалгаж баримтжуулсан болно.

нутаг Үнэгт уулаас илэрч олдсон байдаг (Зураг 5b), (Vanwezer et al. 2021). Харин эдгээр үхэр тэрэгний зарим нарийвчилсан хэсгүүд тэр бүр морин тэрэгний дүрслэлүүдэд тохиолдохгүй байх онцлогтой. Тухайлбал, хоёр тэргийг арлаар нь залгасан хэлбэртэй дөрвөн дугуйт тэрэгнүүд Алтай, Хангайн хадны зураг дахь тохиолдох боловч Богинын амны Баян хайрханы зургийн адил хойд дугуйг жижгээр дүрсэлсэн тохиолдол бараг үгүй юм. Хадны зураг дахь морин тэрэг нь ихэвчлэн нэг аралтай, хос морь хөллөсөн байх бөгөөд хөллөгөөний хоёр морийг нуруугаар нийлүүлсэн байх ба цөөн тохиолдолд мөн нэг тийш харуулан дүрсэлдэг байна. Харин Богинын амны Баян хайрхан болон Үнэгт уул хадны зураг тус бүрт ганц үхэр хөллөсөн байх бол нэг морь хөллөсөн дэлгэмэл тэрэгний дүрслэл бараг үгүй юм. Түүнчлэн Ловонгийн нурууны хүрлийн үеийн үхэр тэрэгт хөллөсөн хоёр үхрийг хөлийн улаар нь нийлүүлэн хоёр тийш харуулан дүрсэлсэн онцлогтой (Баасандорж 2018: 77). Хөллөгөөний хоёр морийг хоёр тийш харуулсан буюу улаар нь нийлүүлэн дүрсэлсэн нь тун цөөн бөгөөд Цагаан салаагийн хадны зурагт нэг удаа тохиолдож байна (Jacobson-Tepfer 2012. Fig 4c).

Ерөнхийлөн дүгнэхэд Баян хайрханы хадны зураг дахь бугын дүрслэлүүд нь буган хөшөөний хэв загвартай төдийгүй тэргийг хүрлийн үеийн аргаар дэлгэмэл байдлаар дүрсэлсэн ч дээр дурдсан морин тэрэгнээс ялгарах зарим онцлогт үндэслэн тус зургийг хожуу хүрлийн төгсгөл үе буюу НТӨ Х-VII зуунд холбогдуулан үзэх бололцоотой.

Мөн Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Баруун булгийн адаг Шар хороот хэмээх газраас нэг үхэрт хөллөсөн, хоёр аралтай тэрэгний зургийг илрүүлэн бүртгэсэн байдаг (Анхсанаа нар. 2019: 83). Тус тэргийг ерөнхийд нь хүрлийн үеийн загвараар буюу тэргийг дээрээс нь, харин хөллөсөн үхрийг хажуу талаас нь харуулсан ба үхрийг хоёр хөлтэй, хомбон эвэртэйгээр дүрсэлжээ (Зураг 6.a). Харин дугуйг цагариг хэлбэрээр дүрсэлсэн ба нэг дугуйны гол хэсэгт мэдэгдэхүйц дугуй цэг тавьжээ. Ийм хэлбэрийн хоёр аралтай тэрэг тийм ч олон илэрч олдоогүй бөгөөд 2015 оны хээрийн судалгаагаар Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутгаар Шийр уул орчмоос нэг дор дүрсэлсэн хоёр аралтай 3 тэргийг илрүүлж олж байв (Зураг 6.b-d). Мөн Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын нутаг Их бэрх уул (Санжмятав 1997), Ловонгийн нурууны Хар чулуут (Баасандорж 2016: 68) зэрэг газарт тус бүр хоёр аралтай тэрэг дүрсэлсэн байна. Эдгээр тэргэнд мал хөллөөгүй боловч Хар чулуутын тэрэгний арлын үзүүр хэсэгт буга бололтой амьтныг дүрсэлсэн байна. Судлаач С.Тэргүүнбаярын тэмдэглэсэн 170 тэрэгний 150 нь нэг аралт, 11 нь хоёр аралт тэрэг байсан талаар

дурдсан төдийгүй Ховд аймгийн Үенч сумын Ямаан усны хадны зурагт нэг болон хоёр аралт тэрэг хамт дүрслэгдсэн байгаагаас үзэхэд нэг үед ашиглагдаж байсан бололтой хэмээн үзжээ (Тэргүүнбаяр 2012: 263).

Харин археологич Санжмятав хоёр аралтай хигээс бүхий хоёр дугуйтай тэргийг Ноён уул, Тэвш ууланд малтсан хүннү булшнаас олдсон тэрэгний дурсгалтай харьцуулан үзэхэд Хүннү улсын үед буюу НТӨ III-NT I зуунд хамаарах төлөвтэй гэжээ (Санжмятав 1997: 78). Гэвч эдгээр хоёр арал бүхий тэргийг хүрлийн үеийн тэрэг дүрслэх ерөнхий аргаар буюу дэлгэмэл байдлаар дүрсэлсэн байх ба хүннүгийн үед тэргийг хажуу талаас проекцлон зурах арга нэгэнт дэлгэрсэн байжээ (Төрбат 2015). Мөн бидний өгүүлэн буй Богинын амны Баян хайрханы хүрлийн үеийн үхэр тэргийг хос аралтай дүрсэлсэн байх учир хүрлийн үед тэргийг нэгэнт хос аралтай дүрслэх болсон байсныг харуулна. Тиймээс Шар хороотын тэрэг нь хүрлийн үеийн тэрэгний үндсэн шинжийг харуулж буй бөгөөд өдгөө илэрч олдоод буй хожуу хүрлийн үед холбогдох 4 дэх үхэр тэрэгт тооцогдох юм.

Түүрүү төмөр болон эртний улсуудын үеийн үхэр тэрэг

Хажуу талаас харсан байдлаар нэг дугуйтай дүрсэлсэн буюу хоёр дугуйт үхэр тэрэгний дүрслэл харин тооны хувьд бусад үеийн үхэр тэрэгнээс харьцангуй олон бөгөөд 8 дурсгалт газарт 11 зураг байна. Тэдгээрийн ихэнх нь Алтайн нурууны дагуух газрын хад чулуунд дүрслэгдсэн байх бөгөөд Монгол Алтайн нурууны эхээс эхлээд Говь-Алтайн нурууны төгсөл хүртэл тархжээ. Алтайн нурууны дээд хэсгээс эхлэн дурдвал Баян-Өлгий аймгийн Шивээт хайрхан (Зураг 7a) - (Кубарев 2009; Jacobson-Tepfer 2012), Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хонгиогийн голын Баян-Энгэр (Зураг 7c-d) - (Ожередов и др. 2009), Ховд аймгийн Манхан сумын Хүрэн дэл (Зураг 7e) – (Энхтөр, Мөнхбат 2020), Говь-Алтайн нуруу буюу Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын нутаг Их бэрх уул (Зураг 7f) – (Санжмятав 1997; Энхтүвшин, Санжмятав 2006), Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Эрдэнэ хайрхан (Зураг 7j-k) – (Түмэн нар. 2010) зэрэг газраас олджээ. Харин хоёр тэрэг нь Хангайн нуруунаас илэрч олдсон байна. Энэ нь Архангай аймгийн Тариат сумын Чулуут голын Аваргын булан (Зураг 7h) – (Санжмятав 1995; Батболд, Содномжамц 2022) болон Цэцэрлэг сумын Өвгөн хонгорж уулын тэрэг² (Зураг 7g) – (Архангай 2015) тус бүр болно.

² Өвгөн хонгорж уулын тэргийг тус аймгийн соёлын өвийн үл хөдлөх багийнхан 2015 онд илрүүлэн олсон боловч хэвлэж нийтлэгдээгүй байна.

Дээрх 2 газар зүйн бүсчлэлд хамаарахгүй нэгэн тэрэг байгаа нь Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын үхэр тэрэг болно (Зураг 7i) – (Баттулга 1998).

Эдгээр нь бүгд загвар хийц төстэй мухлагт тэрэгнүүд бөгөөд он цагийн хувьд ойролцоо цаг үед хамаарах боломжтой ч Шивээт хайрханы тэрэг нь дүрслэлийн хувьд ялимгүй өөр. Тухайлбал, тэрэгний арлаас дээш гарсан хигээс бүхий өндөр дугуйтай, намхавтар ачаа эсвэл мухлагтай бөгөөд зургийг хөвөөлөх аргаар сийлбэрлэсэн байна. Тус тэргийг судлаачид түрүү төмрөөс эртгүй үед холбогдоно хэмээн үзсэн (Jacobson-Terfer 2012), (Зураг 7a). Тус дурсгалт газарт дээрх тэрэгтэй ойролцоо өөр нэгэн дэлгэмэл байдлаар дүрсэлсэн хигээс бүхий том дугуйтай тэрэгний дүрслэл байх бөгөөд тус тэргэнд үхэр хөллөсөн бололтой байна (Зураг 7b). Эдгээр тэрэг нь нэг дурсгалт газарт байх төдийгүй дугуйны тэрэгтэй харьцах хэмжээ, хигээс, хоёр аралтай тэргэнд нэг үхэр хөллөсөн байдал зэргээр тун төстэй тул эдгээр тэргийг нэг цаг үед буюу дээрх судлаачдын үзсэнтэй ойролцоо магадгүй түрүү төмрийн үед дүрслэгдсэн байж болох юм. Харин хоёр дахь тэргийг дугуйг дэлгэмэл маягаар дүрсэлсэн учраас хүрлийн үеийн тэрэгний дүрслэх ерөнхий арга мөн тусгагдсан гэж хэлж болохоор билээ. Тиймээс эдгээр тэргийг ойролцоо цаг үед буюу түрүү төмрийн үед хамруулан авч үзэх боломжтой төдийгүй хигээс бүхий дөрвөн том дугуйтай тэрэг мөн түрүү төмрийн үеийн Пазырькийн булшнаас илэрч олдсон байдаг (Rudenko 1970).

Харин Шивээт хайрханы тэрэгнээс бусад тэрэгний хэв загвар, дүрслэл хоорондоо тун төстэй (Зураг 6с-к) тул ойролцоо цаг үед авч үзэх бүрэн боломжтой. Хонгиогийн голын Баян-Энгэрийн хадны зураг дахь хоёр үхэр тэрэгний нэгийг Ю.И.Ожередов нарын судлаачид хэвлүүлсэн ба хүннүгийн үед холбогдоно хэмээн үзсэн (Ожередов нар. 2009) бол археологич Ч.Мөнхбаяр түрүү хүрлийн үед буюу Хэмцэг болон Мөнххайрханы соёлтой холбох санал гаргажээ (Мөнхбаяр 2019: 103). Харин Дэл уулын үхэр тэрэгний зургийг булшнаас гарсан эдлэл дээрх тэрэгний дүрслэл болон Ховд аймгийн Үенч сумын Ямаан усны морьт тэрэг зэрэгтэй харьцуулан Хүннүгийн үед холбогдох тухай санал дэвшүүлсэн байдаг (Төрбат 2015: 52) бол Их бэрх уул болон Хүрэн дэлийн үхэр тэрэгнүүдийг судлаачид мөн л Хүннүгийн үед холбогдуулан авч үзэх санал дэвшүүлжээ (Санжмятав 1997: 78; Энхтөр, Мөнхбат 2020: 71). Мөн Хүннүгий үеийн хадны зургийн нэг онцлог нь дүрслэлийн бодит чанар, хөдөлгөөнт шинж гэж үздэг (Батболд 2014: 113).

Юутай ч эдгээр мухлагт тэрэгнүүдийн тэрэг болон хөллөсөн үхрийг хажуу талаас нь харсан

байдлаар нэг дугуйтай, харин үхрийн явж байгаа байдлыг тодотгон дүрсэлсэн онцлогтой төдийгүй бүгд хүн зорчих зориулалттай юм (Зураг 7). Харин мухлагийн хэлбэрээр эдгээр 9 тэргийг 3 хэсэгт хувааж болохоор байна.

Нэгдүгээрт: Дээд тал өргөн трафиц хэлбэрийн босоо мухлагтай тэрэг. Энэ хэлбэрт Хүрэн дэл болон Баян-Энгэрийн хоёр үхэр тэрэг, мөн Чулуут голын Аваргын булангийн тэрэг хамаарна (Зураг 7c,d,e,h). Баян-Энгэрийн хоёр тэрэг нь нэг дор байрлах төдийгүй дүрслэлийн хувьд тун адилхан байхын зэрэгцээ үхрийн явдлыг нарийн тод харуулсан ба нэгэн цаг үед хамаарах нь тодорхой байна. Мөн ойролцоо бүс нутагт байрлах Хүрэн дэлийн үхэр тэрэгний мухлагийн хэлбэр тэр дундаа мухлагийн хоёр талаас дээш илүү гарсан үзүүр нь Баян-Энгэрийн хоёр тэрэгтэй адилхан ба бусдаар тэрэгний зарим эд ангийн жижиг ялгаа л ажиглагдаж байна. Харин газар зүйн байршлын хувьд хол гэж үзэж болох Хангайн нурууны Чулуут голын Аваргын булангийн зургийг хөвөөлдөх аргаар цоохортуулан дүрсэлсэн бөгөөд үхрийн 2 эвэр болон хөлийг холболгүй задгүй дүрсэлсэн зэрэг онцлогтой ч мухлагийн хэлбэрээр нь бусад гурван тэрэгтэй адилгаж үзэж болохоор юм.

Хоёрдугаарт: Бөмбөгөр орой бүхий мухлагтай буюу сүйх тэрэг. Ийм хэлбэрт Их бэрх уул, Өвгөн хонгорж уул, Дэл уул зэрэг газраас олдсон үхэр тэрэгнүүд хамаарна (Зураг 7f,g,i). Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Бурхан толгойн булшнаас илэрсэн үйсэн савны таган дээр хажуу талаас дүрслэлтэй, бөмбөгөр орой бүхий тэрэгний дүрслэл (Төрбат 2015) мөн Ховд аймгийн Үенч сумын нутаг Ямаан усны хадны зураг дахь морь хөллөсөн сүйх тэрэг зэрэг нь дээрх үхэр хөллөсөн мухлагт тэрэгнүүдтэй ойролцоо хэв загвартай болно. Ялангуяа шинээр илэрсэн Өвгөн хонгорж уулын тэрэгний мухлаг бөмбөгөр оройтой байхаас гадна оройны (шүхэр) хүрээ ирмэг ялимгүй дээш эргэсэн байна. Эдгээрээс Их бэрх уулын хоёр үхэр тэрэг бүрийн хөллөгөөний үхрийг 2 хөлтэй дүрсэлсэн бол Дэл уул болон Өвгөн хонгорж уулын хөллөгөөний үхрийг тус бүр 4 хөлтэй, явж буй алхааг нарийн гаргаж дүрсэлсэн байх төдийгүй Өвгөн хонгорж уулын хадны зургийн үхэр тэрэг хөтлөөд явж буй хүний алхааг ч мөн тодорхой гаргаж дүрсэлжээ.

Гуравдугаарт: Дөрвөлжин хэлбэрийн мухлагтай тэрэг. Энэ хэлбэрийн тэргэнд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Эрдэнэ хайрханаас олдсон хоёр үхэр тэрэг багтана (Зураг 7j,k). Тус хоёр тэрэгний нохой дагуулан яваа тэрэг нь нь өндөр тавцантай бөгөөд мухлагийн урд талд хүн суун үхэр тэргийг жолоодож яваа бөгөөд мухлагийн дээд орой урагш илүү гарч жолоочийг нар, борооноос хамгаалсан. Харин нөгөө тэрэгний

мухлаг дотор нэгэн хүн сууж яваа ба тус хоёр үхэр тэрэгний мухлагийн хоёр талд дээш илүү гарч цухуйсан үзүүрт саглагар цацаг мэт зүйлийг дүрсэлжээ.

Хүннүгийн язгууртны булшнаас морь хөллөх, язгууртны сүйх тэрэгний олдвор олонтоо илэрч олддог ч энгийн үхэр тэрэгтэй холбогдох олдвор цөөн илэрч олджээ. Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Ховд аймгийн Мөнххайрхан сумын Шомбуузын бэлчир зэрэг газраас олдсон модон эд ангиудыг үхэр тэрэгний хэсэг хэмээн үзсэн байна (Цэвээндорж 1987; Miller 2012). Мөн Хятад сурвалжид хүннүчүүдийн үхэр тэрэгний талаар мэдээ огт дурдагдахгүй байгаа билээ (Sima Qian 1993). Харин Орхон аймгийн Жаргалант сумын Айрагийн гозгорт малтсан Сяньбийн үеийн булшнаас шувуун оройтой мухлаг бүхий үхэр тэрэгний модон загвар илэрч олдсон байна (Зураг 7), (Одбаатар 2021).

Гэр тэрэг

XIII зуунд Монголчууд олон үхэрт хөллөдөг гэр тэрэгтэй байсныг Францын аялагч Виллиам де Рубрук (1220-1293) өөрийн биеэр үзэж хэмжсэн тухайгаа бичиж үлдээжээ. Түүний өгүүлснээр “Тэд гэрээ маш том хэмжээтэй хийдэг ба зарим нь 30 футь өргөнтэй. Нэг удаа нэгэн гэр тэрэгний өргөнийг хэмжихэд дугуй хоорондын зай 20 футь, тэргэн дээр байрлуулсан гэр нь дугуйнаас хааш хаашаа дор хаяж 5 футь илүү гарсан байна. Хөллөсөн үхрийг тоолж үзэхэд хоёр эгнээ тус бүр 11 үхэр, нийт 22 үхэр хөллөсөн ба улмаар тэргэн дээрх гэрийн хаалганы өмнө нэгэн эр зогсож хөллөсөн үхрээ туудаг” гэжээ (Rockhill 1900), (Зураг 8b). Ийм хэлбэрийн гэр тэрэгний эртний хэлбэрийг харуулахуйц археологийн баримт хэрэглэгдэхүүн бол 1986 онд БНХАУ-ын Ганьсу мужийн Юймэнь хот дахь Хан, Вэй улсын үеийн хотын ойролцоогоос түүвэр байдлаар олдсон авсны модон дээрх дүрслэл юм (Зураг 8a). Уг зурагт гэр бүхий хоёр тэрэг дүрсэлсэн ба зүүн гар талд байх тэргийг нэг үхэрт хөллөсөн бол баруун гар талд байх тэргийг малд хөллөөгүй, харин гэрт нэг хүн зогсож байгааг нээлттэй хаалгаар харагдах байдлаар дүрсэлжээ. Мөн тэдгээрийн дунд хэсэгт үхэр тэргийг хөтөлсөн бололтой хоорондоо хөтлөлцсөн хоёр хүнийг зурсан байна. Уг авсны модонд C14-ийн аргаар он цаг тогтоох шинжилгээ хийхэд HT IV-V зууны үед холбогдох нь тогтоогджээ (Beijing Daxue 2011). Уг тэргэн дээр байрласан гэр нь бөмбөгөр орой, өндөр дөрвөлжин цамхраа бүхий тооно, өндөр хана туурга, хаалга зэргийг тодорхой дүрсэлсэн нь өнөө цагийн нүүдэлчдийн эсгий гэрээс төдий л их ялгарах зүйлгүй харагдана. Уг гэр тэргэнд Рубрукийн тэмдэглэсэн шиг олон үхэр хөллөсөн

бус боловч ийм хэлбэрийн гэр тэргийг нүүдэлчид бүр эрт үеэс хэрэглэж байсан болохыг харуулж буй юм. Мөн ОХУ-ын, Буриадын Бүгд Найрамдах улсын Цармын хөндийн хүннүгийн 7-р булшнаас илэрсэн үйсэн саван дээрх гэр болон гэр тэрэгний зургууд (Miniaev, Sakharovskaia 2007: 51) нь хүннүчүүд гэр сууцанд амьдарч байсныг шууд нотлох олдвор төдийгүй туг хиур бүхий хоёр чингэлэг тэрэгний ханыг гэрийн хана мэт нүд гарган зурсан болох нь тодорхой харагдаж байна. Ий хэлбэрийн өндөр цамхраа бүхий тоонотой гэрийн зургийг Баянхонгор аймгийн Галуут сумаас Цагаан туруутын голоос илрүүлж олсон байдаг (Түвшинжаргал, Тэйлор 2019: 10-11). Түүнчлэн Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бичигтийн хаднаа гэр тэрэг болон бусад гэр хэлбэрийн дүрсүүдийг сийлбэрлэсэн байх бөгөөд археологич Д.Цэвээндорж гэр тэрэгний зурагтай цуг дүрслэгдсэн зэрэгцээ зогссон хоёр хүн, гурван янгир зэргийн дүрсэлсэн арга барилд үндэслэн хүрлийн үед холбогдоно хэмээн үзсэн (Цэвээндорж 2003: 54) бол бусад судлаачид Хүннүгийн үед хамааруулжээ (Сүхбаатар 2000: 35-36, 41; Батболд 2014: 113).

Хэлэлцүүлэг

Алтайн нурууны бүс нутагт эртний үхэр тэрэгний баримт хэрэглэгдэхүүн маш ховор бөгөөд хадны зургийн дүрслэлд үхэрт нуруу ачсан, хөтөлсөн болон унасан зураг түгээмэл тохиолддог. Уг шалтгаан нь байгалийн бартаа саад, тухайлбал чулуу ихтэй, өндөр эгц уулстай холбоотой байж болно (Түвшинжаргал 2022). Тухайлбал, Хөвсгөлийн Дархад ястны нутаг уул, даваа, гол ус ихтэй учир энд тэрэг хөсгөөр нүүх боломж байхгүй учир тэргийг дээр үеэс огт хэрэглэж байгаагүй бөгөөд мэддэггүй аж (Бадамхатан 1965: 98). Дархадын нүүдэл уулын нүүдэлд ордог ба нүүх гол арга бол мал нуруу ачиж нүүх явдал юм (Бадамхатан 1965: 98). Түүнчлэн Алтайн нурууны Захчингууд тэмээ болон сарлагаар нуруу ачиж нүүдэг байна (Туулцэцэг 2020: 78). Харин зүүн монголын тал хээрийн бүсийн нүүдэлчид тэргээр нүүдэллэх бөгөөд тэргэнд гол төлөв үхэр хөллөдөг ялгаатай (Цэрэнханд 1996: 101; Дисан 1996: 147).

Гэсэн хэдий ч Монгол улсын нутгаас илэрсэн тэрэгний хамгийн эртний баримтууд нь мөн л Алтайн бүс нутгаас илэрч олдсон байна. Хар чулуутаас олдсон түрүү хүрлийн үед холбогдох мал хөллөөгүй, цул дөрвөн дугуйт тэргийг дээд талаас нь буюу дэлгэмэл байдлаар харуулан дүрсэлсэн нь (Зураг 2.а) хожуу хүрлийн үеийн тэрэг дүрслэх нийтлэг арга барилтай ижилсэж байгаа юм. Тиймээс ийм хэлбэрийн дүрслэлтэй тэрэг хүрлийн эрт үед ч хамаарах боломжтойг харуулж буй билээ. Түүнчлэн Дэл уулнаас олдсон

урагш түрсэн эвэртэй, биеийн ерөнхий тэгийг хөвөөлдөж, улмаар эрээлсэн тэрэгний үхэр нь дүрслэлийн хувьд хүрлийн үед тэр дундаа түрүү болон хөгжингүй хүрлийн үед хамаарах боломжтой юм. Гэсэн ч тэргийг хажуугаас дүрсэлсэн байдлаар нь хүрлээс хожуу үед хамааруулж болох ч түрүү хүрлийн үеийн Өмнөд сибирийн Окуневийн соёлын хөшөө чулуунд тэргийг хажуу талаас дүрсэлсэн тохиолдол байх төдийгүй, дугуйг цагариг хэлбэрээр дүрсэлж, дунд нь цэг тавьсан ч хигээстэй дугуйг илтгэхгүй юм. Дээрх үндэслэлүүдээр Дэл уулын үхэр тэргийг (Зураг 3.б) тэрэгний хөгжлийн эхэн үед холбогдуулж үзэж болохоор байна.

Мөн хожуу хүрлийн үеэс адуу тээвэрт зонхилох үүрэг гүйцэтгэх болсон нь хиргисүүр, буган хөшөөний тахилгын байгууламжаас гадна энэ үед холбогдох хадны зураг дахь морин тэрэгний тооноос харагддаг. Монгол улсын нутгаас олдсон хадны зураг дахь хүрлийн үеийн морин тэрэг болон тэрэгний дүрслэл 400 орчимд хүрсэн болохыг тэмдэглэсэн (Анхсанаа 2017: 83) ба зөвхөн Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Шивээт хайрхан, Цагаан салаа, Бага-Ойгорын хадны зурагт л гэхэд л 132 тэрэг дүрслэгдсэн байдаг (Jacobson-Terfer 2012). Энэхүү тоог тухайн цаг үед холбогдох 4 үхэр тэрэгтэй харьцуулахад хол зөрүү харагдаж буй учир нэг талаас энэ үед үхрийг тэргэнд хөллөх нь ховор байсан гэж харагдаж байгаа боловч нөгөө талаар тухайн үед үхрийг тэргэнд хөллөдөггүй биш адуу нь хурд хүчний бэлгэдэл болсон амьтан тул морин тэргийг хаданд дүрслэх элбэг байсан гэж үзэж болох юм.

Хаданд сийлсэн морин тэрэгний ихэнх нь байлдааны бус жирийн аж ахуйн зориулалттай хэмээн үзсэн байдаг (Цэвээндорж 1977) бол өөр зарим судлаачид хадны зураг дахь тэрэгний дүрслэл нь нас барагчийг дараагийн амьдралд хүргэх утга агуулгатай гэжээ (Jacobson-Terfer 2012: 9). Өвөр хадны Ихэрийн хожуу хүрлийн үеийн үхэр тэрэгний тавцан дээрх хүн нум сумаар янгир авлаж байх (Зураг 5.а) бөгөөд үхэр тэргээр янгир агнах нь тийм итгэл үнэмшил төрүүлэхгүй ч харин агнасан ан амьтад, ялангуяа том биетэй амьтдыг үхэр тэргэнд ачиж, тээвэрлэхэд ашигладаг байсан байж болох юм.

Харин Богинын амны Баян хайрханы хожуу хүрлийн үеийн зурагт (Зураг 4) урт хөлтэй боловч буган хөшөөний адил загварчлан дүрсэлсэн таван бугын доод талд үхэр тэрэг болон тэргэн дээр суусан нэг хүн, хөтөлсөн өөр нэг хүнийг дүрсэлсэн байх бөгөөд энэ орчимд өөр хадны зураггүй билээ. Харин тус энгэрт хэд хэдэн дөрвөлжин булш байрлана. Тиймээс эдгээр хоёр хүн нь тухайн газраар үхэр тэрэгтэй зорчин явахдаа хангайн сүрлэг амьтадтай тааралдсан явдлаа мөнхөлж

хаданд зурах болов уу? Эсвэл нөгөө талаар энэ нь магадгүй хойд насны агуулгатай зураг ч байж болохоор юм. Тухайлбал, буга нь тэнгэрийн амьтан, бөө хүний онгодын унаа болдог, сүнс тээдэг, хамгаалагч, өвөг дээдсийн дүр болдог ид шидтэй амьтан гэх ойлголтууд байдаг бөгөөд буган хөшөөн дээрх бугын дүрс нь тухайн хүний сүнсийг тэнгэрт хүргэгч, хамгаалагч гэсэн утгатай хэмээн тайлбарлажээ (Баярсайхан 2017: 85). Хэрэв ингэж үзвэл хадны зураг дахь буган хөшөөний бугатай ижил загварчилсан дүрслэлт буганууд нь мөн адил утга санаа илэрхийлнэ гэжээ (Батболд 2020: 43). Хадны зураг нь ямар ч утга агуулгагүй, энд тэнд санамсаргүй зурсан зүйл бус (Дорж 1962: 77) бөгөөд тухайн эрт цаг үеийн тахилга шүтлэгтэй, ариун дагшин газар хэмээн ойлгож болно.

Евразийн хэмжээнд тэргийг оршуулгад дагалдуулах уламжлал маш эртнээс буюу НТӨ IV-III мянганд хамаарах бөгөөд манай улсын нутагт орших эртний олон соёлын оршуулгын дурсгалаас тэрэг илэрч олддог. Нэг талаар Пазырык булшны оршуулгад дагалдуулсан адуунд бугын маск өмсгөсөн байгаа нь энэ насны унаа болсон адуу нь бугын дүрст хувиран хойд насанд хүргэдэг санаа байж болох бөгөөд морин тэрэгний урд талд хосоор болон нэгээр буга дүрсэлсэн тохиолдол хадны зурагт цөөнгүй тохиолдож байгаа (Новгородова 1984: 68) нь бас санамсаргүй тохиолдол биш бололтой.

Мөн хожуу хүрлийн үеийн хиргисүүрийн хэлбэрийг ч цөөнгүй судлаачид морин тэрэгний бүтэцтэй адилгаж тайлбарладаг (Худяков 1987: 158; Батсайхан 2002: 130; Taylor et al. 2021; Lepetz et al. 2021). Тэгэхлээр тухайн чулуугаар дүрслэн үйлдсэн тэрэг (хиргисүүр) нь мөн л тухайн нас барагчийг дараа төрөлд, эсвэл сүнсийг тэнгэрт хүргэх гэсэн ижил утга илэрхийлж байна. Мөн хиргисүүрийн эздэд зориулан хүнчилж бүтээсэн буган хөшөөн дээр ч морин тэрэг дүрсэлсэн байх аж (Дорж, Новгородова 1975: 77; Волков 2002: 218; Нямбат, Одбаатар 2010: 63).

Өөр нэг зүйл бол хадны зурагт мал хөллөөгүй сул тэргийг дүрслэх явдал олонтоо тохиолддог төдийгүй мөн хоёр аралтай тэрэгт голчлон мал хөллөөгүй байгаа юм. Тиймээс эртний хүмүүс ямар утга санааны үүднээс эдгээр дан тэргийг хаданд дүрслэх болов гэдэг асуулт урган гарч буй бөгөөд үүнийг мөн л оршуулгын зан үйлтэй холбон тайлбарлаж болох мэт. Учир нь өдгөө Монгол угсаатнуудын дунд шарил тээвэрлэсэн тэргийг газар дээр нь орхидог, хэрэв орхиогүй бол ирмэгц гэрийн өмнө талд тэрэгний арлыг гэрийн зүг харуулан аль нэг талын дугуйг салгаж 3 хоног тавьдаг зан үйл байна (Дисан 1996: 187). Магадгүй эрт цагт нас барагчийг тээвэрлэсэн тэргийг оршуулгад дагалдуулах, эсвэл хээр үлдээхийн

оронд хаданд дүрсэлж үлдээдэг уламжлалтай байгаад хожим хүннүгээс хойшхи эртний улсуудын үеэс тэрэгний жижиг загварыг хийх эсвэл, бунхны ханад зурах гэх мэтээр төлөөлүүлэх хэлбэрт шилжсэн гэж үзэх болох юм. Учир нь Сяньбигийн үеийн булшнаас үхэр тэрэгний загварууд илрэх төдийгүй (Одбаатар 2021: 11; 陈筱娇 2018: 365) Умард Вэй улсын үеийн нэгэн бунхны ханын тоосгон дээр шарил ачсан (гэрийн хананд ороосон) бололтой үхэр тэрэг дүрсэлжээ (王江鹏 2012: 17). Үүнийг мөн л оршуулгад тэрэг дагалдуулдаг эрт цаг үеийн зан үйлийн нэгэн хэлбэр гэж харж болно. Тэрэг нь нүүдэлчдийн аж ахуй, амьдралд чухал хэрэгцээтэй тул нийгмийн дээд давхаргын хүмүүсийн оршуулгад л бодит тэрэг дагалдуулдаг болохыг археологийн малтлагаар илэрсэн тэрэгний олдвороос харж болно. Харин жирийн иргэдийн хувьд нас барсан хүн бүрт тэрэг дагалдуулах нөөц боломж бага байх нь ойлгомжтой учир өөрөөр буюу хад чулуунд сийлбэрлэх, жижиг загварыг нь хийж оршуулгад дагалдуулах хэлбэрээр зан үйл гүйцэтгэдэг байж болох билээ.

Хүннү болон эртний улсуудын үед холбогдуулан авч үзэж буй хажуу талаас дүрслэлтэй үхэр тэрэгнүүд (Зураг 7с-к) дотор цаашид анхаармаар нэг зүйл байгаа нь Баян-Энгэрийн хоёр үхэр тэрэгний нэгний доод талд скиф хэлбэрийн бодит дүрслэлт буга цуг дүрслэгдсэн явдал юм. Энэ хоёр зураг нэгэн цаг үед зурагдсан эсэх тодорхой бус хэрэв тийм бол эдгээр үхэр тэрэг мөн хүннүгээс арай эрт үе хамаарах уу гэдэг асуудал тулгарч байна. Хэрэв скиф загварын бугатай нэг дор дүрслэгдсэнээр нь Баян-Энгэрийн үхэр тэргийг наанадаж түрүү төмрийн үед холбогдуулж үзэх болвол ижил загвартай буюу трафци хэлбэрийн мухлагтай тэрэгнүүд магадгүй хүннүгээс арай эрт үед хамаарч магадгүй. Гэвч тус бодит дүрслэлт бугыг хоёр хөлтэй, буган хөшөөний дүрслэлийн адил биеэ хураан цомцойн зогсож буй бол үхэр тэрэгний үхэр нь гурван хөлтэй байхын зэрэгцээ үхрийн явдлыг чадмаг илэрхийлсэн дүрслэлийн ялгаа ажиглагдаж байгаа нь нөгөө талаар бас он цагийн зөрүүг илтгэж бас магадгүй юм. Харин сүйх хэлбэрийн тэрэгнүүд ялангуяа Өвгөн хонгорж уулын тэрэг нь илт хүннүгийн үед холбогдох бололтой.

Дүгнэлт

Дотоод Ази тэр дундаа Алтайн бүс нутагт тэрэг анх хэрэглэх болсон нь НТӨ IV мянганы төгсгөл, III мянган жил бөгөөд холбогдогчид нь Афанасьев, Хэмцэгийн соёлт ард түмэн юм. Харин тэрэгний гол зүтгэх хүч нь үхэр байсан байх магадлалтай төдийгүй энэ үеэс тэргийг дэлгэмэл байдлаар буюу дээрээс харсан байдлаар хаданд дүрслэх арга барил бий болжээ. Гэсэн ч хад чулуу, модтой

өндөр уулын бүс нутагт үхэрт нуруу ачих болон унах хэлбэр давамгай хөгжиж, харин тэргэнд хөллөж төдий л ашигладаггүй байсан учраас үхэр тэрэгний эрт үеийн дүрслэл тун ховор байдаг бололтой. НТӨ II мянганы II хагас болоход хурдан шаламгай чадвараар шалгарсан адууг тэрэгний зүтгэх хүчинд түгээмэл ашиглах болж, тээвэрт зонхилох үүрэг гүйцэтгэх болсон нь хадны зураг дахь олон тооны морин тэрэгний дүрслэлээс харагдаж байна. Тиймээс тухайн цаг үеийн нийгмийн байдал болон хүмүүсийн оюун санаанд адуу онцгой байр суурь эзлэх болсон тул үхэр тэргийг хаданд дүрслэх явдал ховор байжээ.

Бидний хожуу хүрлийн үед холбогдуулж үзсэн 4 үхэр тэрэг ялангуяа Богинын амны Баян хайрхан болон Үнэгт уулын үхэр тэрэгнүүд нь хэдийгээр хүрлийн үеийн тэрэгний адил дэлгэмэл байдлаар дүрслэгдсэн байх ч тэдгээр тэргийг нэг малд (үхэр) хөллөсөн байгаа нь тухайн цаг үеийн морин тэрэгний дүрслэлд төдий л тохиолдохгүй учир он цагийн арай хожуу үед буюу НТӨ X-VII зууны үед холбогдох магадлалтай. Энэ нь нэг талаас хожуу хүрлийн тэрэг болон хөллөсөн малыг дэлгэмэл байдлаар дүрслэх аргаас эртний улсуудын үеийн тэргийг хажуу талаас проекцлон зурах аргын шилжилтийн үеийг илэрхийлж байж магадгүй эсвэл нэг мал хөллөдөг тэрэг өргөн дэлгэрч эхэлсэн цаг хугацааг харуулна.

Харин эртний улсуудын үед холбогдуулж үзсэн хажуу талаас проекцлон зурсан үхэр тэрэгнүүд нь ерөнхий дүрслэлээр гурван ялгаатай хэлбэрт хуваагдаж буй боловч хөдөлгөөнт хэв шинж, хажуугаас дүрслэх арга барил хийгээд тэрэгний мухлагийн хийц зэргээр хүннү болон бусад эртний улсуудын үед хамаарах боломжтой юм. Чухам Баян-Энгэрийн үхэр тэрэг нь скиф хэлбэрийн бодит дүрслэлтэй бугатай цуг дүрслэгдсэн буйг цаашид анхаарууштай. Түүгээр зогсохгүй нүүдлийн хэв маягт зохицсон гэр тэрэгний хэлбэр ч лавтай хүннүгийн үеэс гарал үүсэлтэй болох нь археологийн баримт хэрэглэгдэхүүнээс харагдаж байна.

Тэрэг нь нэг талаар үхэгсдийн хүүрийг тээвэрлэх чухал хэрэгсэл болдог учраас хойд насны ойлголттой эрт үеэс сүлэлдэж ирсэн болохыг түүхэн олон цаг үеийн оршуулгад тэрэг дагалдуулдаг зан үйлээс харж болно. Тийм ч учраас магадгүй хиргисүүрийн хэлбэрийг тухайн нас барагчийг эсвэл тэдний сүнснийг хойд насанд хүргэнэ гэсэн ойлголтоор тэрэгний бүтэцтэй үйлдэхээс гадна хадны зурагт дахь зарим тэрэгний дүрслэлүүд ч мөн оршуулгын утга агуулгатай байж болзошгүй байна.

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 03 сарын 31

Өгүүлэл засварласан: 2023 оны 04 сарын 15

Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 6 сарын 30

Ном зүй

Анхсанаа 2017 – Анхсанаа, Г. Цагаан усны голын хадны зураг. //Studia Archaeologica. Том XXXVI, Fasc 7. УБ., 2017, т. 81-98.

Анхсанаа нар. 2019 – Анхсанаа, Г., Энхбат, Г., Цоож, А. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XIII дэвтэр. Өмнөговь аймаг. УБ., 2019.

Архангай 2015 – Архангай аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2015 оны улсын үзлэг тооллогын тайлан. Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан. Соёлын өвийн үндэсний төв. УБ., 2015.

Баасандорж 2016 – Баасандорж, Г. Ловонгийн нурууны хадны зураг. УБ., 2016.

Баасандорж 2018 – Баасандорж, Г. Баян уулын хадны зураг. УБ., 2018.

Бадамхатан 1965 – Бадамхатан, С. Хөвсгөлийн Дархад ястан. //Studia Ethnographica. Том III, Fasc 1. УБ., 1965.

Байпаков, Марьяшев 2004 – Байпаков, К.М., Марьяшев, А.М. Петроглифы в горах Кульжабасы. Алматы, 2004.

Батболд 2011 – Батболд, Н. Хүннүгийн хадны зураг //Хүннүгийн өв. Редактор Г.Эрэгзэн. УБ., 2011, т. 96-101.

Батболд 2014 – Батболд, Н. Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа. УБ., 2014.

Батболд 2020 – Батболд, Н. Төв Азийн хадны зураг ба буган хөшөө. //Studia Archaeologica. Том XXXIX, Fasc 4. УБ., 2020, т. 39-55.

Батболд, Содномжамц 2022 – Батболд, Н., Содномжамц, Д. Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе) суурь судалгааны төсөлт ажлын 2022 онд Архангай аймгийн Тариат сумын нутагт хийсэн хадны зургийн судалгааны ажлын тайлан. ШУА, Археологийн хүрээлэн. УБ., 2022.

Батсайхан 2002 – Батсайхан, З. Хүннү. УБ., 2002.

Баттулга 1998 – Баттулга, Ц. Дэл уулын Баруун билүүний II, III бичээс //Studia Archaeologica. Том XVIII, Fasc 9. УБ., 1998, т. 109-115.

Баярсайхан 2017 – Баярсайхан, Ж. Монголын умард нутгийн буган хөшөөд. УБ., 2017.

Волков 2002 – Волков, В.В. Оленные камны монголии. М., 2002.

Гей 2000 – Гей, А.Н. Новотиторовская Культура (Novotitorovskaya Culture). Российская Академия НАУК, Институт Археологии. М., 2000.

Дисан 1996 – Дисан, Т. Үзэмчин //Монгол улсын угсаатны зүй 3. УБ., 1996, т. 129-195.

Дорж 1962 – Дорж, Д. Монгол орны хад чулуун дээрх зураг сүгийн зүйл. //Studia Historica. Том II, Fasc 8. УБ., 1962, т. 75-88.

Дорж, Новгородова 1975 – Дорж, Д., Новгородова, Э.А.. Петроглифы Монголии. Часть I. Улан-Батор, 1975.

Есин 2018 – Есин, Ю.Н. Древнейшее приспособление для управления тягловыми животными на востоке Евразийского степного пояса. Научное обозрение Саяно-Алтая 1(21), 2018, с.115-125.

Ковалев 2012 – Ковалев, А.А. Древнейшие статуи Чемурача и прилегающих территорий. С-П., 2012.

Ковалев, Эрдэнэбаатар 2014 – Ковалев, А.А., Эрдэнэбаатар, Д. Исследования ритуальных оград Чемурачского облика и связанных с ними памятников в Баян-Ульги аймаке Монголии в 2004 году. //Древнейшие европейцы в сердце Азии: Чемурачский культурный феномен. Часть I. Результаты исследований в восточном Казахстане, на севере и юге Монгольского Алтая. С-П., 2014, с. 163-392.

Ковалев, Мунхбаяр 2015 – Ковалев, А.А., Мунхбаяр, Ч. Чемурачский ритуальный комплекс Хар чулуут 1 В, истоках реки Ховд (Кобдо), (Предварительное сообщение). //Древнейшие европейцы в сердце Азии: Чемурачский культурный феномен. Часть II. Результаты исследований в центральной части Монгольского Алтая и в истоках Кобдо; памятники Синьцзяна и окраинных земель. С-П., 2015, с. 155-214.

Ковалев, Мунхбаяр 2022 – Ковалев, А.А., Мунхбаяр, Ч. Петроглифы на Чемурачских ритуальных оградах в высокогорье Монгольского Алтая (3 ТЫС ДО Н.Э.): репертуар образов. Төв Азийн эртний нүүдэлчдийн хадны зураг. Ред Н.Батболд. УБ., 2022, т. 84-95.

Кубарев 2009 – Кубарев, В.Д. Петроглифы Шивээт-хайрхана. (Монгольский Алтай). Издательство Института археологии и этнографии СО РАН. Новосибирск, 2009.

Монголын... 2008 – Монголын Говь-Алтайн хадны зураг. Зүүн Хойд Азийн түүхийн сан/ ШУА-ийн Археологийн хүрээлэн. Сөүл 2008.

Мургабаев 2013 – Мургабаев, С.С. Проблемы хронологии и культурных связей ранних петроглифов Каратау. Научное обозрение Саяно-Алтая 1(5). 2013, с. 52-65.

Мөнхбаяр 2019 – Мөнхбаяр, Ч. Ховд аймгийн нутагт шинээр илэрсэн тэрэгний зургийн тухай. Түүхийн товчоон. Ховд Их сургууль. Том X, Fasc 5. 94-112.

Новгородова 1984 – Новгородова, Э.А. Мир петроглифов Монголии. М., 1984.

- Новоженков 2014** – Новоженков, В.А. К вопросу о происхождении а-образного типа двуколки минусинской котловины. //Археология, этнография и антропология Евразии 2 (58), 2014, с. 90-110.
- Нямбат, Одбаатар 2010** – Нямбат, М., Одбаатар, Ц. Зүүнхангай сумын нутгаас шинээр олдсон буган хөшөөд. //Нүүдэлчдийн өв судлал. Том X, Fasc 4. УБ., 2010, т. 57-66.
- Одбаатар 2021** – Одбаатар, Ц. Айрагийн гозгорын модон сийлбэрүүд. //Монголын археологийн нэвтэрхий толь. УБ., 2021, т.11.
- Ожередов и др. 2009** – Ожередов, Ю.И., Мунхбаяр, Ч., Ожередов, Ю.А. Новые находки археологических памятников в северных сомонах Ховдского аймака западной Монголии. Түүхийн товчоон IV, т. 138-148. Ховд Их сургууль, 2009.
- Саблин 2014** – Саблин, С.В. Определения костных остатков животных из раскопок курганов раннего периода бронзового века на территории Уланхус сомона Баян-Ульги аймака Монголии (2004 год). //Древнейшие европейцы в сердце азии: Чемурачский культурный феномен. Часть I. Результаты исследований в восточном Казахстане, на севере и юге Монгольского Алтая. Редактор А.А.Ковалев. Санкт-Петербург, 2014, с. 234.
- Самашев и др. 2014** – Самашев, З., Мургабаев, С., Еленов, М. Петроглифы Сауыскандыка. Филиал Института археологии им. А.Х. Маргулана в г. Астана. 2014.
- Санжмятав 1995** – Санжмятав, Т. Монголын хадны зураг. ШУА, Түүхийн хүрээлэн. УБ., 1995.
- Санжмятав 1997** – Санжмятав, Т. Нүүдэлчдийн түүх соёлыг хадны зургаар судлах нь. //Төв Азийн нүүдэлчдийн соёл иргэншлийн зарим асуудал I. Редактор, Ш.Нацагдорж. УБ., 1997, т. 67-80.
- Сүхбаатар 2000** – Сүхбаатар, Г. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал. МЭӨ IV-МЭ II зуун. УБ., 2000.
- Сэр-Оджав 1987** – Сэр-Оджав, Н. Баянлигийн хадны зураг. БНМАУ-ын Шинжлэх ухааны академи, Түүхийн хүрээлэн. Редактор Д.Дорж. Шинжлэх ухааны академийн хэвлэл. УБ., 1987.
- Төрбат 2015** – Төрбат, Ц. Эгийн голын хүннү булшнаас гарсан үйсэн дээрх тэрэгний зураг. // Монгол-Францын археологийн нээлтүүд хорин жилийн хамтын ажиллагаа. УБ., 2015, т. 49-53.
- Төрбат 2019** – Төрбат, Ц. Хэмцэгийн соёлын хадны зураг (2015 оны өгүүлэл). //Studia Archaeologica. Том XXXVIII, Fasc 1. УБ., 2019, т. 5-16.
- Туулцэцэг 2020** – Туулцэцэг, Ч. Захчны түүх, угсаа, соёлын судалгаа (XVII-XX зуун). Түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилох бүтээл. Монгол улсын их сургууль. УБ., 2020.
- Түвшинжаргал, Тэйлор 2019** – Түвшинжаргал, Т., Тэйлор, В. Гэрийн эртний түүхэн хөгжлийг археологийн хэрэглэгдэхүүнээр тодруулах нь. //Монгол гэрийн өв соёл. Монголын үндэсний музей. УБ., 2019, т. 5-11.
- Түвшинжаргал 2022** – Түвшинжаргал, Т. Тээвэрт үхэр ашиглах хэлбэр, түүний үүсэл хөгжил, уламжлал. //Төв Азийн эртний нүүдэлчдийн хадны зураг. Ред Н.Батболд. УБ., 2022, т. 130-144.
- Түмэн нар. 2010** – Түмэн, Д., Эрдэнэбат, У., Эрдэнэ, М. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Сүмбэр, Билүүтийн талбайд явуулсан археологийн хайгуул, малтлага судалгааны тайлан. Монгол Улсын Их сургууль. УБ., 2010.
- Тэргүүнбаяр 2012** – Тэргүүнбаяр, С. Төв азийн хадны зургаас эртний нүүдэлчдийн тэрэгний загвар, бүтцийн хувьслыг шинжлэх нь. //Монгол болон Байгал нуур орчмын Сибирийн эртний соёл. УБ., 2012, т. 246-282.
- Худяков 1987** – Худяков, В.С. Херексуры и оленные камни. АЭАМ. Новосибирск. 1987.
- Цэвээндорж 1977 – Цэвээндорж, Д. Хадны сийлмэл зургийн шинэ дурсгал. //Studia ethnographica. Том V, Fasc 5, УБ., 1977, т. 73-118.
- Цэвээндорж 1987** – Цэвээндорж, Д. Хүннүгийн археологи //Studia Archaeologica. Том XII, УБ., 1987, т. 58-81.
- Цэвээндорж 2003** – Цэвээндорж, Д. Монголын археологи, урлагийн шинэ олдворууд. // Studia Archaeologica. Том I(XXI), Fasc 4. УБ., 2003, т. 52-58.
- Цэрэндагва, Цэвээндорж 2016** – Я.Цэрэндагва., Д.Цэвээндорж. Далан түргэний хос толгойн хадны зураг. ШУА, Түүх, Археологийн хүрээлэн. УБ., 2016.
- Цэрэнханд 1996** – Г.Цэрэнханд. Барга //Монгол улсын угсаатны зүй 3. УБ., 1996, т. 78-85.
- Энхтөр, Мөнхбат 2020** – Ч.Энхтөр., Ц.Мөнхбат. Мянган үеийн түүхт өгүүлэх Манхан нутаг. УБ., 2020.
- Энхтүвшин, Санжмятав 2006** – Б.Энхтүвшин., Т.Санжмятав. Нүүдэлчдийн соёл ба монголын хүрэл зэвсгийн үеийн дурсгал. УБ., 2006.
- Anthony 2007** – Anthony, David W. The Horse, The Wheel, and Language: How Bronze-Age Riders from the Eurasian Steppes Shaped the Modern World. Princeton University Press. 2007.
- Beijing Daxue 2011** – Beijing Daxue and Gansu Sheng Wenwu Kaogu Yanjiusuo. Hexi Zoulang shiqian kaogu diaocha baogao (Report on Archaeological Investigations of the Prehistory of the Hexi Corridor). Wenwu Chubanshe, Beijing, 2011. 340, 338-339.
- Jacobson-Tepfer 2012** – Jacobson-Tepfer, Esther. The image of the Wheeled Vehicle in the Mongolian Altai: Instability and Ambiguity. The Silk Road 10, 2012, p. 1-28.

Kovalev and Erdenebaatar 2009 – Kovalev, A.A. and Erdenebaatar, D. Discovery of new cultures of the Bronze Age in Mongolia according to the data obtained by the International Center Asian archaeology expedition. In *Current Archaeological Research in Mongolia 4*, edited by Jan Bemmann, 2009, pp 149-170. VFGARCH.Press uni-Bonn, Bonn.

Kowaloski et al. 2019 – Kowaloski, L, K. Adamczak, A. Garbacz-Klempka, P. Degryse, Z. Stos-Gale, M. Kozicka, W. Chudziak, A. Krzyszkowski, and A. Jedynek. Back to the Eneolithic: Exploring the Rudki-Type Ornaments from Poland. *Archaeological and Anthropological Sciences* 11. 2019, p. 4355-4377.

Kuzmina 2008 – Kuzmina, Elena E. *The Prehistory of the Silk Road*. University of Pennsylvania Press. Philadelphia, 2008.

Lepetz et al. 2021 – Lepetz, S., Bernard, V., Cerivel, M., Joly, D., Bayarkhuu, N., Saunier, I., Turbat, Ts., and Zazzo, A. Occupation et espaces sacres dans l'Altai mongol. – Editions Mergoïl, 2021.

Miller 2012 – Miller, B.K. Vehicles of the Steppe Elite: Chariots and Carts in Xiongnu Tombs. *The silk road*, 10. 2012, p. 29-38.

Miniaev and Sakharovskaia 2007 – Miniaev, S.S., Sakharovskaia L.M. Investigation of a Xiongnu Royal Complex in the Tsaraam Valley. Part 2: The Inventory of Barrow 7 and the Chronology of the Site. // *Silk road* 5. 1 (2007): 51.

Morgunova and Turetsky 2003 – Morgunova, N. L and Turetsky, M. A. (2003). Pit-Grave monuments at the village of Shumayevo: New Data on Wheel Transport at the Population of the Western Orenburg Oblast during an era of Early Metal. *Voprocii arheologii Povoljya - Issue of archaeology in Volga river region* 3:344-159.

Novozhenov 2012 – Novozhenov, V.A. *Communications and the Earliest Wheeled Transport of Eurasia*. TAUS Publishing, Moscow, 2012.

Reinhold et al. 2017 – Reinhold, S., Gresky, J., Berezina, N., Kantorovich, A.R., Knipper, C., Maslov, V.E., Petrenko, V.G., Alt, K.W., and Belinsky, A.B. Contextualizing Innovation: Cattle Owners and Waggon Driver in the North Caucasus and Beyond. In *Appropriating Innovations: Entangled Knowledge in Eurasia, 5000-1500 BCE*, edited by J. Maran, & P. Stockhammer. 2017, pp. 78-97. Oxbow Books.

Rudenko 1970 – Rudenko, S.I. *Frozen tombs of Siberia: The Pazyryk Burials of Iron Age Horseman*. Translated by M.W. Thompson. University of California press. Berkeley & Los Angeles, 1970.

Rockhill 1900 – *The Journey of William of Rubruck to the Eastern part of the World, 1253-1255*. By William Woodville Rockhill. London., 1900, 53-55.

Rogozhinskiy 2011 – Rogozhinskiy A.E. Rock Art Sites in Kazakhstan. In *Rock Art in Central Asia: A Thematic Study*, edited by J. Clottes, pp. 9 - 42. International Council on Monuments and Sites, Paris, 2011.

Sherratt 1981 – Sherratt, A. Plough and Pastoralism: Aspects of the Secondary Products Revolution. In *Pattern of the Past*, edited by I. Hodder, G. Isaac and N. Hammond, 1981, pp. 155–199. Cambridge University Press.

Shishlina et al. 2014 – Shishlina, N., Kovalev, D., & Ibragimova, E. (2014). Catacomb culture wagons of the Eurasian steppes. *Antiquity*, 88(340), 378-394. doi:10.1017/S0003598X00101061.

Sima Qian 1993 – Sima Qian (1993). *Shi Ji 110: The account of the Xiongnu*.

Taylor et al. 2021 – Taylor, W., Cao, J., Fan, W., Ma, X., Hou, Y., Wang, J., ... Miller, B. Understanding early horse transport in eastern Eurasia through analysis of equine dentition. *Antiquity*, 95(384), 1478-1494. doi:10.15184/aqy.2021.146


Vanwezer et al. 2021 – Vanwezer, N., Taylor, W. T. T., Bayarsaikhan, J., Breitenbach, S. F. M., Amano, N., Louys, J., ... Petraglia, M. Hunting, herding, and people in the rock art of Mongolia: New discoveries in the Gobi-Altai Mountains. *Archaeological Research in Asia*, 26, 100267, 2021. <https://doi.org/10.1016/J.ARA.2021.100267>.

陈筱娇 2018 - 陈筱娇. 中国古代设计中的“胡化”与汉胡融合现象研究. 南京. 2018年.



王江鹏 2012 - 王江鹏. 魏晋南北朝墓葬人物图像与艺术转型. 博士学位论文. 西安美术学院. 2012.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.




Зураг 1. Үхэр тэрэгний тархалтын зураг. Түрүү хурлийн үе: 1-Хар чулуут; Хожуу хурлийн үе: 2-Богиньн амны Баян хайрхан, 3-Үнэгт уул, 9-Ихэр, 5- Шар хороот; Түрүү төмрийн үе: 6-Шивээт хайрхан, Хүннү ба эртний улсуудын үе: 7-Хүрэн дэл, 8-Баян-Энгэр, 4-Их Бэрх уул, 10-Өвгөн хонгорж уул, 11-Чулуут голын Аваргын булан, 12-Айрагийн гозгор, 13-Дэл уул, 14-Эрдэнэ хайрхан.



Зураг 2. Түрүү хурлийн тэрэг. 2a – Хар чулуутын хавтан чулуун дээр дүрсэлсэн дөрвөн дугуйт тэрэг (Ковалев, Мөнхбаяр 2015); b – Казакстаны Сауыскандыкийн хадны зураг дахь үхэр тэрэгнүүд (Мургабаев 2013).




Зураг 3. 3a - Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Далан түргэний хос толгойн хадны зураг дахь тэрэг болон үхрийн дүрслэл (Цэрэндагва, Цэвээндорж 2016). 3b - Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Дэл уулнаас олдсон үхэр тэрэгний тойм дүрслэл (Санжмятав 1995).




Зураг 4. Төв аймгийн Борнуур сумын Богинын амны Баян хайрханаас шинээр илрүүлсэн хадны зургийн дурсгал (гэрэл болон гар зураг)





Зураг 5. Хожуу хурлийн үеийн үхэр тэрэг. a – Говь-Алтай аймгийн Баян-Уул сум, Өвөр хадны Ихэр (Баасандорж 2018:77); b – Говь-Алтай аймгийн Чандмань сум, Үнэгт уул (Vanwezer et al. 2021); c – Төв аймгийн Борнуур сум, Богинын амны Баян хайрхан.



Зураг 6. а - Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг Шар хороотоос илэрсэн 2 аралтай үхэр тэрэг (Анхсанаа нар. 2019). b-d - Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг Шийр уул орчмоос илэрсэн хоёр аралт тэрэгнүүд



Зураг 7. а-b - Баян-Өлгий аймгийн Улаанхус сум, Шивээт хайрхан (Кубарев 2009; Jacobson-Tepfer 2012); с - Ховд аймгийн Манхан сум, Хүрэн дэл (Ц.Мөнхбатын гэрэл зургаас дахин зурж буулгасан хувилбар); d-e - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Баян-Энгэр (Зохиогч); f - Говь-Алтай аймгийн Баян-Уул сум, Их бэрх уул (Монголын... 2008); g - Архангай аймгийн Тариат сум, Чулуут голын Аваргын булан (Батболд, Содномжамц 2022); h - Архангай аймгийн Цэцэрлэг сум, Өвгөн хонгорж уул (Архангай 2015); i - Дундговь аймгийн Өлзийт сум, Дэл уул (Батболд 2011); j-k - Өмнөговь аймгийн Гурвантэс сум, Эрдэнэ хайрхан (М.Эрдэнийн гэрэл зургаас буулгаж зурав); l - Орхон аймгийн Жаргалант сумын Айрагийн гозгорын булинаас илэрсэн үхэр тэрэгийг загварын сэргээсэн хуулбар (Одбаатар 2021).



Зураг 8.а - БНХАУ-ын Ганьсу мужийн Юймэнь хот дахь Хан, Вэй улсын үеийн хотын ойролцоогоос түүвэр байдлаар олдсон авсны модон дээрх зураг (Beijing Daxue 2011); б – Монголын эзэнт гүрний үеийн гэр тэрэг. Италийн зураач Куинто Сенни (1845-1917).